



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 8/41

Өлгий

Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах хүсэлтийг шийдвэрлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.4 заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 6 дугаар зүйлийн 6.2, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.12, 13.19 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн шинжээчийн бүрэлдэхүүний 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн эрх шинээр олгох, сунгах, эрхийг хүчингүй болгох байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Клиникийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлагуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүссэн эмийн сан, клиникүүдэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах шинжээчийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



Эрүүл мэндийн газрын даргын
... оны 06 сарын 04 өдрийн 1 дүгээр тоот
тушаалын ... хавсралт

**НЭГ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ ШИНЭЭР
ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	"Камора"	Эмийн сан	3 жилээр	2028.06.04
2	"Дэлүүн-Монос"	Эмийн сан	3 жилээр	2028.06.04

**ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ СУНГАГДСАН
БАЙГУУЛЛАГУУД:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	"Еланфарм фарммаркет"	Эмийн сан	5 жилээр	2030.05.09
2	"IQ's" clinic	Арьс, гоо заслын клиник	5 жилээр	2030.06.16

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ:

1. Дэлүүн сум 12-р баг "Нур мекен" ХХК-ийн "Монос Дэлүүн" эмийн сан
2. Алтай сум 4-р баг "Дармек" ХХК-ийн "Дармек 3" эмийн сан
3. Өлгий сум 11-р баг "Хашаатын цагаан чулуу" ХХК-ийн "Тод фарм" эмийн сан

ДӨРӨВ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1. "Нурлы" ХХК-ийн "Нурлы" ортой эмнэлэгт Аймгийн нэгдсэн эмнэлгийн Дүрс оношилгооны эмч Х.Тилеужаны ажлын бус цагаар гэрээгээр ЭХО үзлэг хийх хүсэлтийг дэмжив.